

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

Гэр бүлийн бодлогын газрын Хүүхдийн эрхийн
хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч
Жанцандоржийн Азжаргалын
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт								
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
НЭГ.ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
2.2.МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ								
2.4.3-ЫН ХҮРЭЭНД:								
Зорилт 1: Хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангах								
1.	Арга хэмжээ 1.1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын МУЗГ-ын 6,7 дугаар тайланг боловсруулж, НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд хүргүүлнэ. /Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн 49 дүгээр	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	-	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 03/771 дугаар албан бичгээр “Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хорооны Нарийн бичгийн дарга нарын газраас 2027 оныг хүртэл Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит 6, 7 дугаар хамтатгасан илтгэлийг хялбаршуулсан журмаар бэлтгэж хүргүүлэх хуваарь хойшилсон”-ыг уламжилсан.	Тайлангийн хугацаа хойшилсон	Үнэлэх боломжгүй	

	зүйл/						
2.	Арга хэмжээ 1.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн эзлэх хувь	0%	50%	1/ Аймаг, дүүрэг, сум дундын шүүхтэй суманд 38 Хүүхдийн эрхийн хууль шинэчлэгдэн байгуулагдаж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40-43 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2/ Архангай, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Орхон, Говьсүмбэр аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулагдаж, 110 гишүүн, хорооны ажлын алба хамрагдаж, чадавхжсан. 3/ ТНБД-ын 2025 оны "Журам боловсруулж, батлуулах тухай" А/85 дугаар тушаал батлуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасан "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам"-ын төслийг боловсруулах ажлыг эхлүүлж, баримт бичгийн шинжилгээ хийгдэж байна.	2025.01-09-06.05	90%
3.	Дэд арга хэмжээ 1.2.1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн шинэчлэх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэл хүргүүлж, хяналт тавина.	Гүйцэтгэлийн хувь	0%	50%	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний 03/64 дугаар албан бичгээр Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40.1-40.6-д заасны дагуу шинэчлэн байгуулах, чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, үйлчилгээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай чиглэл хүргэсэн. Үүний үр дүнд 38 хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, Архангай, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Орхон, Говьсүмбэр аймаг, нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн Хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулагдаж, 110 албан хаагч, хууль зүйн хорооны ажлын албаны гишүүд сургалтад хамрагдан чадавхжсан байна.	2025.01.09	100%